

ТАНИЛЦУУЛГА

“Хүн худалдаалахтай тэмцэх
үндэсний хөтөлбөрийн төслийн
талаар”

Монгол Улсын Их хурлаар 2012 оны 1 дүгээр сарын 19-ны өдөр батлагдсан Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтад заасны дагуу Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг боловсруулан танилцуулж байна.

Сүүлийн үед үндэстэн дамнасан, зохион байгуулалттайгаар үйлдэгддэг хар тамхи, хүн худалдаалах зэрэг гэмт хэрэг ихсэх хандлагатай байгаа бөгөөд иргэд өөрсдийн эрх зүйн мэдлэг дутмагаасаа болж энэ төрлийн гэмт хэрэгт холбогдох явдал өсөх хандлагатай байна.

Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн зорилго нь Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Улсын хэмжээнд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, иргэдийг энэ төрлийн гэмт хэрэгт өртөхөөс өөрийгөө болон бусдыг хамгаалах мэдлэг чадвартай болоход нь дэмжлэг үзүүлэх, урьдчилан сэргийлэхэд оршино.

Гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхэд иргэд, иргэдийн сайн дурын бүлгэм, зөвлөл болон төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлж тэдний үйл ажиллагааг дэмжих, урамшуулах тогтолцоог бий болгож ажиллах нь энэ хөтөлбөрийн бас нэг зорилго юм.

Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг 2017-2021 хүртэл 4 жилийн хугацаатай хэрэгжүүлэхээр төлөвлөж хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, зарцуулагдах хөрөнгийн төсвийг хамтад нь боловсрууллаа. Мөн хөтөлбөрийг боловсруулахдаа урьдчилан сэргийлэх, хамгаалах, мөрдөн шалгах, хамтын ажиллагаа гэсэн 4 чиглэлийг удирдлага болголоо.

Санхүүжилтийн хувьд улс, орон нутгийн төсөв, гадаад улс, олон улсын байгууллагын хандив, тусламж, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, хөрөнгө зэрэг эх үүсвэрээс санхүүжүүлэхээр тусгалаа.

Энэхүү хөтөлбөрийг батлан хэрэгжүүлсэнээр хүн худалдаалах гэмт хэргийн төрлүүд болох бэлгийн мөлжлөг, хөдөлмөрийн мөлжлөг, зуучлалын захиалгат гэрлэлт, хүүхэд үрчлэлт, эд эрхтэний наймаа зэрэг үндэстэн дамнасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх болон гэмт хэрэгт өртсөн хохирогчийг хамгаалах, тэдний эрүүл мэндийг нөхөн сэргээх, зорилтод бүлгүүдэд чиглэсэн сургалт, сурталчилгааны ажлыг явуулахдаа оновчтой хэлбэрийг сонгон тэдний нас биений онцлог, сонирхол, мэдээлэл авах шаардлага хэрэгцээг тооцон орчин үеийн сургалтын дэвшилттэй талыг ашиглаж явуулах нөхцөл бүрдэх юм.

Иймд дээрх шалтгаан нөхцөл, батлагдан гарсан хууль тогтоомжид нийцүүлэн хөтөлбөрийн зорилго, чиглэл, үйл ажиллагааг тусгасан Засгийн газрын тогтоолын төслийг боловсрууллаа.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ